



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 16 өдөр

Дугаар A/591

Ховд

Г Газар эзэмших эрх шилжүүлэх тухай Г

Монгол Улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Жаргалан багийн нутагт 1 дүгээр 12 жилийн сургуулийн хойд талд байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай Чимэдийн Чинбат /БД74071216/-ийн эзэмшлийн 383.0 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Майдаржавын Илчгэрэл /ПЮ75070701/-д хаягийг Залуус 1 дүгээр гудамжны 101 тоот болгон 15 жилийн хугацаагаар,

2. Жаргалант сумын Буянт багийн Эко 1 дүгээр гудамжны 36 тоотод байрлах, амины орон сууцны зориулалттай Нямхүүгийн Энхмандах /ПЮ72100376/-ийн эзэмшлийн 962.0 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Дүнхэрийн Чимэдцэрэн /ПЭ55112604/-д хаягийг Цэцэрлэгт хүрээлэнгийн 1 дүгээр гудамжны 142 тоот болгон 15 жилийн хугацаагаар,

3. Жаргалант сумын Бичигт багийн 1 дүгээр гудамжны 01 тоотод байрлах, үйлдвэрлэлийн зориулалттай "Эпу-хайрхан" ХХК- /2374552/-ний эзэмшлийн 1750.0 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу "Мөнхийн дулаан гэр" ХХК /6427774/-д хаягийг Г.Аюурзана 5 дугаар гудамжны 508 тоот болгон 15 жилийн хугацаагаар тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

4. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлж газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд

Zax A/591.Ch  
02 02940

заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг дээрх иргэн, аж ахуйн нэгжид үүрэг болгосугай.

5. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэн, аж ахуйн нэгжтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ